

## МОНГОЛ УЛС БА АСЕАН-Ы ХАМТЫН АЖИЛЛАГАА

*Ж. Уянга\**

АСЕАН буюу Зүүн өмнөд Азийн улсуудын холбоонд Вьетнам, Бруней, Лаос, Кампучи, Малайз, Сингапур, Тайланд, Филиппин, Мьянма, Индонези зэрэг улсууд ордог. Энэ бүс нутаг дулаан орны хөдөө аж ахуйн болон эрдэс баялгийн их нөөцтэй, ажиллах хүч, үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын ихээхэн ирээдүйтэй зах зээл юм. Сүүлийн жилүүдэд АСЕАН-ы орнуудын удирдлага бүс нутгийн эдийн засгийн чадавхийг улам илүү нээж эрчимтэй хөгжихийн тулд өөр хоорондын болон олон улсын эдийн засгийн интеграцийг чухалчлах болсноор бүс нутгийн хамтын ажиллагаа, интеграцийн түвшин улам бүр гүнзгийрч, бүс нутгийн илүү өргөн хүрээтэй интеграцид хүрэх чиглэлд явж байгаа ба үйл ажиллагаа нь боловсронгуй болон хөгжиж байна. АСЕАН-ы интеграцийн гол зорилго нь бүс нутгийн орнууд эдийн засгийн хөгжлийг түргэтгэх, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх явдал юм.

Бүс нутгийн эдийн засгийн интеграцийг хөгжүүлэх нь улс орнуудын хооронд итгэлцлийг бэхжүүлэх, газар нутгийн маргааныг зохицуулах, түүхийн элдэв санал зөрөлдөөнийг шийдвэрлэхэд тус дөхөмтэй юм. Энэ утгаараа хүн ам нь цөөн, тархай бутархай оршдог, уламжлалт хөдөө аж ахуй нь байгалийн эрхшээлд байдаг, дэд бүтэц сул хөгжсөн Монгол орны хувьд бүс нутгийн интеграцид оролцох, түүнд Монгол Улсын үүрэг оролцоог нэмэгдүүлэх нь чухал ач холбогдолтой юм. Зүүн Азийн хамтын нийгэмлэгийн бүлэглэлд ордог орнууд нь Монгол Улсын хөрш зэргэлдээ буюу ойр оршихоос гадна манай улстай найрсаг харилцаатай улсууд билээ. Сүүлийн жилүүдэд Монгол Улс Зүүн өмнөд Азийн улс орнуудтай улс төр, эдийн засаг, соёлын салбарт харилцаа, хамтын ажиллагааг улам бүр өргөжүүлж байгаа билээ. Монгол Улс АСЕАН+3 /Зүүн өмнөд Азийн улсуудын холбоо + БНСУ, Хятад, Япон/ үйл явцыг анхнаас нь дэмжсэн билээ. Монгол Улсын гадаад бодлого, үйл ажиллагаа энэхүү хамтын нийгэмлэгийн зорилго, зарчимд бүрэн нийцэж байгаа бөгөөд ийм учраас Монгол Улс 2005 оны 7 дугаар сард “АСЕАН-ы Найрамдал, хамтын ажиллагааны Гэрээ”- нд нэгдэн орсон юм. Энэхүү гэрээнд нэгдэн орсон нь АСЕАН-ы орнуудтай хоёр талын

\* Ж.Уянга - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

болон олон талын үндсэн дээр худалдаа, эдийн засгийн өргөн харилцааг хөгжүүлэх нь манай улс төрийн болоод худалдаа, эдийн засгийн дипломат ажиллагааны ойрын жилүүдийн тулгамдсан зорилт юм.

АСЕАН-ы орнууд бүс нутгийн эдийн засгийн интеграцийн хүрээнд худалдаа ба хөрөнгө оруулалтыг чөлөөлөхөөс гадна улс доторхи хурдны зам ба төмөр замын сүлжээнүүд, боомтууд, далайн замууд, дотоодын усан замын тээвэр болон иргэний агаарын гол гол шугамуудаас бүрдэх Транс-АСЕАН-ы тээврийн сүлжээг хөгжүүлэх асуудал чухал байр эзэлж байгаа юм. Мөн АСЕАН-ы эрчим хүчний болон Транс-АСЕАН хий дамжуулах төслүүдээс бүрдэх Транс-АСЕАН-ы эрчим хүчний сүлжээнүүдийг бий болгох ажлууд хийгдэж байна.

Монгол Улсын хөгжлийн ирээдүйтэй холбоотой асуудал бол бүс нутгийн хөгжлийн дэд бүтэцтэй холбоотой асуудал юм. Манай улс АНДЭЗНК /Ази Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс, НҮБ/-ын санаачилсан Азийн автозамын сүлжээ, Транс-Азийн төмөр замын сүлжээ байгуулах төслүүдэд идэвхтэй оролцож ирсэн. 2000 оноос эхлэн хэрэгжүүлж байгаа Монгол Улсын Засгийн газрын “Мянганы зам”-ын бүтээн байгуулалтын ажил амжилттай явагдаж байгаа ба энэхүү авто замын бүтээн байгуулалт нь Азийн авто замын сүлжээтэй уялдаж байгаа бөгөөд цаашид бүсийн орнуудын хамтын хөгжилд ихээхэн чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн, АСЕАН-ы Бүсийн Чуулга Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудын хооронд яриа хэлэлцээ өрнүүлэх, итгэлцлийг бэхжүүлэх тал дээр анхааран ажиллаж байна.

### **Зүүн өмнөд Азийн орнуудтай хийсэн Монголын худалдаа**

Экспорт: Монгол Улс дэлхийн 70 оронд бараа, түүхий эд экспортлож нийт экспортын 16.1 хувь Европын орнуудад, 56.6 хувь Азийн орнуудад, 25.9 хувь Америк тивийн орнуудад тус тус ногдож байна. Монгол орон Зүүн өмнөд Азийн орнуудаас гол төлөв Сингапур, Вьетнам орнуудад түүхий эд экспортлодог. Экспортын бүтэц нь үндсэндээ түүхий эд, эрдэс баялгаас бүрдэж байгаагийн хагас нь уул уурхайн бүтээгдэхүүн болох зэсийн баяжмал, алт юм.

Улс орон, газар нутаг	Экспортын үнийн дүн, мянган ам.доллар			Экспортод эзлэх хувийн жин, %		
	2003	2004	2005	2003	2004	2005
Сингапур	35035.6	19883.7	611.3	5.8377	3302	0.0580
Вьетнам	15.7	0.0	14.2	0.0026	0.0000	0.0013

Импорт: Манай улс дэлхийн 91 орноос гарал үүсэлтэй бараа импортлосон байна. Европын орнуудаас үүсэлтэй бараа 47.1 хувийг, Азийн орнуудын бараа 46.5 хувийг эзлэж байгаа нь нийт импортын 93.6 хувийг эзлэж байна. Зүүн өмнөд Азийн орнуудаас Малайз, Филиппин, Сингапур, Тайланд, Вьетнам зэрэг орнуудаас бараа импортолдог байна. Эдгээр орнуудаас ногоон цай, цагаан будаа, элсэн чихэр, шар будаа, ургамлын тос, согтууруулах биш ундаа, хатуу чихэр, янжуур, хуурай сүү г.м импортолдог байна. Сүүлийн үед импортын бүтэцэд цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн хувийн жин нэмэгдэж байна.

Улс орон, газар нутаг	Импортын үнэ			Импортод эзлэх хувь		
	2003	2004	2005	2003	2004	2005
Малайз	4591.8	5497.0	6685.6	0.583	0.5434	0.5820
Филиппин	526.8	2155.4	1062.1	0.067	0.2131	0.0925
Сингапур	10234.2	14939.1	15255.3	1.300	1.4768	1.3221
Тайланд	1449.6	4680.8	848.4	0.184	0.4627	0.2239
Вьетнам	1672.6	2214.3	2376.7	0.212	0.2189	0.2557

*Эх үүсвэр: Монголын гадаад худалдааны  
тойм /2005 оны эцсийн байдлаар/*

### **Монгол дахь Зүүн өмнөд Азийн орнуудын хөрөнгө оруулалт**

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын эдийн засаг макро түвшинд тогтворжиж, эрх зүйн орчин нь тогтворжиж байгаагаас гадаадын хөрөнгө оруулалтыг татах таатай нөхцлийг бүрдүүлж байна. Өнөөдөр манайд дэлхийн 88 орны хөрөнгө оруулалт орж ирээд байна. Монголд нийт компанийн 30.5% нь худалдаа, нийтийн хоолны салбарт, 7.4% нь барилга, барилгын материалын үйлдвэрийн салбарт, 6.1% нь геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолтын салбарт, 5.3% нь аялал жуулчлалын салбарт, 3.8% нь хөнгөн үйлдвэрийн салбарт, 3.7% нь хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байна.

1990-2004 онуудад гадаадын 73 орны нийт 3000 шахам компани нэг тэрбум сая гаруй ам.долларын хөрөнгө оруулалт бүртгэгдсэн. Эдгээрийн 32 хувь нь гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай, 68 хувь нь хамтарсан хөрөнгө оруулалттай компани байна.

Зүүн өмнөд Азийн орнуудаас Сингапур, Малайз хөрөнгө оруулалтаараа тэргүүлж байна. Үүнд: /2004 оны байдлаар, мянган ам.доллар/

	Орон	Хөрөнгө оруулалт	Жин
1.	Сингапур	8.514	0.7 %
2.	Малайз	4.539	0.4 %

*Эх үүсвэр: “Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт, 2006”*

Сингапур орны хөрөнгө оруулагчид цахилгаан хэрэгслийн үйлдвэрлэл, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, мэдээлэл холбооны технологи, аялал жуулчлал, боловсролын салбарыг ихэд сонирхож байна. Малайз орны хөрөнгө оруулагчид аялал жуулчлал, боловсрол, мебель, модон эдлэл, гоо сайхны үйлчилгээ, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн салбарыг сонирхож байна.

Сүүлийн үед манай улсад хөрөнгө оруулагчдын дотор компани, хуулийн этгээдийн эзлэх хувийн жин багасч, хувь хүмүүсийн эзлэх хувь өсөх хандлага ажиглагдаж байна. Эдгээр нь Монголд гадаадын хөрөнгө оруулалтын хүрээ байнга өргөжин тэлж байгааг нотлон харуулж байна.

### **АСЕАН ба Монгол Улсын хамтын ажиллагаа**

2006 оны 7-р сарын 27-28-нд Малайзийн нийслэл Куала Лумпур хотноо хуралдсан АСЕАН-ы Бүсийн чуулга /АРФ/-ын Сайд нарын 13 дугаар уулзалтад Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад хэргийн сайд Н.Энхболд тэргүүтэй төлөөлөгчид оролцсон билээ. Сайд нарын энэхүү уулзалтаар АРФ өөрийн хөгжлийн хоёрдахь үе шат болох урьдчилан сэргийлэх дипломат ажиллагааны түвшинд шилжиж байгааг сайшааж, Ази, Номхон далайн бүс нутгийн өмнө тулгарч буй асуудлууд өөр хоорондоо харилцан уялдаа, хамааралтай, илүү ярвигтай болж байгаа нь бүс нутгийн хамтын ажиллагааг оновчтой хөгжүүлэхийг шаардаж байгаа болохыг онцлов. Сайд нар мөн Ойрхи Дорнодын хямрал, БНАСАУ-ын пуужингийн туршилт, Ираны цөмийн хөтөлбөр зэрэг асуудлыг хэлэлцэв. Чуулга уулзалтаас Монгол Улсыг АСЕМ-д гишүүнээр элсүүлсэн шийдвэр гаргажээ.

Хельсинк хотноо 2006 оны 9-р сарын 10-11-нд болсон Ази-Европын уулзалт /АСЕМ/-ын дээд хэмжээний хуралдаанаар Монгол Улсыг АСЕМ-ын гишүүнээр элсүүлсэн юм. Ази, Номхон далайн бүс нутгийн олон талт хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох гадаад бодлогоо хэрэгжүүлэх хүрээнд хоёр тивийн яриа хэлэлцээний энэхүү механизмд элсэн орсон нь манай улсын гадаад харилцааны цар хүрээг улам тэлсэн үйл явдал болсон юм. АСЕМ-ын гишүүн болсноор Ази-Европын түншлэлийн харилцаанд оролцох өргөн боломжийг манай улсад нээж байгаа юм. Тухайлбал, олон улсын хэмжээнд худалдаа, эдийн засаг, аюулгүй байдлын асуудлаар өөрийн байр сууриа илэрхийлэх, сайдуудын дээд хэмжээний уулзалтад оролцох боломжтой болох аж.

Улс төр, эдийн засаг, соёлын гэсэн үндсэн гурван чиглэлээр явуулдаг АСЕМ-ын үйл ажиллагаанд төр, засаг албаны хүмүүс төдийгүй эрдэм шинжилгээний хүрээлэн, олон нийтийн байгууллага, бизнес эрхлэгчид оролцож сонирхсон асуудлаараа санал бодлоо солилцдог. Гишүүн орнуудын хамтын ажиллагаа өмнө нь голчлон эдийн засгийн салбарт хэрэгжиж байсан бол цаашид эрүүл мэнд, байгаль орчин, эрчим хүч, хөдөлмөр эрхлэлт, шинжлэх ухаан, технологи, мэдээлэл, харилцаа холбоо зэрэг салбарыг хамрахаар болжээ. Түүнчлэн хил дамнасан асуудлууд, тухайлбал, зохион байгуулалттай гэмт хэрэг, эмэгтэйчүүд, хүүхдүүдийг дарлаж ашиглахын эсрэг тэмцэх, хүний эрхийн асуудлыг голчлон хэлэлцэж байхаар тогтов.

Цаашид Монгол Улс АСЕАН-ы орнуудтай хамтын ажиллагааны хүрээнд:

- Худалдаа, хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх.
- Аялал жуулчлалын салбарыг улам хөгжүүлэх
- Байгаль орчин, эрчим хүчний салбарт бодлого, стратегийн асуудлуудаар үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх
- Дэд бүтэц, мэдээллийн технологи, хүний хөгжлийн асуудлуудаар хамтран ажиллах
- Нийгэм, соёл, боловсролын салбарын хамтын ажиллагааг улам бүр хөгжүүлэх, бүс нутагт ядуурлыг бууруулах, нийгмийн шударга ёс, хүний аюулгүй байдлыг сайжруулах замаар нийгмийн тогтвортой байдлыг хангах зэрэг асуудлуудыг голлон, анхааран үзэж хамтран ажиллахад зүйтэй болов уу.

Ийнхүү манай бүс нутагт худалдаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, бүс нутгийн интеграцчиллыг гүнзгийрүүлэх тал дээр олон алхмууд, оролдлого хийгдэж байна. Монгол Улс бүс нутгийн интеграцийн үйл явцад хэдий чинээ идэвхи санаачилгатай оролцоно, төдий чинээ бүсийн орнуудын хөгжлийн хамтын үйл ажиллагаанд ойртон нягтарч, улам бүр хурдтай хөгжин дэвших болно.

### **АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

1. Б.Санжмятав “Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт, 2006”
2. “Монголын гадаад худалдааны тойм /2005 оны эцсийн байдлаар/”, УБ, 2006
3. [www.mofa.go.jp/region/asia-paci/asean/conference/asean/3](http://www.mofa.go.jp/region/asia-paci/asean/conference/asean/3)
4. “Өнөөдөр” сонин, 2006.08.15, №190/2844/
5. “Зууны мэдээ” сонин, 2006.09.13 №220/2356/